



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 28 өдөр

Дугаар № 16/02

Улаанбаатар хот

Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.9 дэх заалт, “МИК Холдинг” ХК-ийн дүрмийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн 2016 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 16/21 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан болон “Эрснт энд Янг Монголиа Аудит” ХХК-ийн гаргасан 2015 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТӨМӨР

“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 28 өдөр

Дугаар № 16/03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.3. дах хэсэг, 8.3.7. дах заалт “МИК Холдинг” ХК-ийн 2016 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 16/23 тоот тогтоолыг тус тус үндэслэн “МИК Холдинг” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

1. Компанийн дүрмийн 5.1 дэх хэсэгт “Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 30,000,000 (гучин сая) ширхэг зарласан энгийн хувьцаатай байна” гэснийг “Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн үнэтэй 30,000,000 (гучин сая) ширхэг зарласан энгийн хувьцаатай бөгөөд түүнээс 20,709,320 (хорин сая долоон зуун есөн мянга гурван зуун хорь) ширхэг энгийн хувьцаа гаргасан байна” гэж өөрчилсүгэй.
2. “МИК Холдинг” ХК-ийн дүрэмд орсон өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгүүлж холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг “МИК Холдинг” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Гантөгс)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.ГАНТӨМӨР



“МИК ХОЛДИНГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 4 сарын 28 өдөр

Дугаар № 16/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.15 дах заалт, Компанийн дүрмийн холбогдох хэсэг, “МИК Холдинг” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх шагнал урамшууллын хорооны 2016 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хурлын дүгнэлтийг тус тус үндэслэн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг Хавсралт 1-д заасны дагуу баталсугай.
2. Зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын №16/04
тоот тогтоолын Хавсралт



"МИК Холдинг" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны зардлын төсөв

| Зардлын төрөл | Сарын цалин | Давтамж | Хүний тоо | Нийт | Үүнээс: | |
|-------------------------------------|------------------|---------|-----------|--------------------|--------------------|--------------------|
| | | | | | 2016 | 2017 |
| Цалин | 5,125,000 | 12 | 15 | 292,500,000 | 195,000,000 | 97,500,000 |
| ТУЗ-ийн дарга | 2,750,000 | 12 | 1 | 33,000,000 | 22,000,000 | 11,000,000 |
| ТУЗ-ийн гишүүн | 2,000,000 | 12 | 8 | 192,000,000 | 128,000,000 | 64,000,000 |
| ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд | 375,000 | 12 | 15 | 67,500,000 | 45,000,000 | 22,500,000 |
| НДШ-ийн зардал | | 12 | | 28,665,000 | 19,110,000 | 9,555,000 |
| НИЙТ | | | | 321,165,000 | 214,110,000 | 107,055,000 |

**Тайлбар*

"МИК Холдинг" ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн хороодын гишүүдийн сарын цалинг тухайн сард биечлэн болон онлайн байдлаар хуралд оролцсон бол олгох, /хэдэн удаа хуралдсанаас үл хамааран/ хэрэв хуралд оролцоогүй бол цалин олгохгүй болно.